

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халхгол сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2025/010/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитор: Ч.Удвалноров Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-7
3. Аудитын илрүүлэлт	8
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	9-10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.24 № 424

танай _____-ны № _____-т

ХАЛХГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Э.БЯМБАЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Халхгол сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Үндсэн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022205

Бусад асуудлын хэсэг

Тус сум нь 2024 оныг “Бүтээн байгуулалт, тохижилтын жил” зорилтот жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд нийт 5 бүлгийн 69 арга хэмжээ хэрэгжүүлэн ажилласан. Сумын ИТХ-ын 2024 оны 03/07 дугаар тогтоолоор 71.8 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,998,421.3	1,084,981.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,337,833.6	473,783.4
33	АВЛАГА	213,243.0	184,970.6
35	БАРАА МАТЕРИАЛ	447,344.7	426,226.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	16,350,218.3	19,133,474.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,350,218.3	19,133,474.4
39200	Биет хөрөнгө	15,959,772.4	18,743,606.2
39300	Биет бус хөрөнгө	390,445.9	389,868.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	18,348,639.6	20,218,455.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	101,106.6	239,295.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	101,106.6	239,295.8
41300	Өглөг	101,106.6	239,295.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	18,247,533.0	19,979,159.6
51	Засгийн газрын хувь оролцоо	18,247,533.0	19,979,159.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,840,833.5	1,840,833.5
51200	Хуримтлагдсан үр дүн	15,731,385.2	17,463,011.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	675,314.3	675,314.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	18,348,639.6	20,218,455.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,394,119.0	9,270,265.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,853,562.2	2,614,032.4
110	Орлогын албан татвар	1,542,201.9	2,074,812.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,552,114.3	2,155,566.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(9,912.50)	(80,754.30)
113	Хөрөнгийн албан татвар	73,111.7	96,122.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,238,248.7	443,098.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,635,363.2	4,386,736.1
120	Нийтлэг татварын бус орлого	1,907,992.7	4,386,736.1
122	Тусламжийн орлого	727,370.5	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,905,193.6	2,269,497.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,753,235.9	5,500,956.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,753,235.9	5,500,956.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,462,435.1	5,221,374.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,544.8	763,240.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,349.7	94,383.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,113.9	680,219.0
2104	Хангамж, бараа материалын зардал	81,481.5	94,891.5
2105	Нормативт зардал	600.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,423.1	30,819.5
2107	Томиллолт, зочны зардал	18,255.3	25,180.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,107,553.8	1,064,105.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,692,113.1	2,468,534.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,290,800.8	279,582.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,640,883.2	3,769,308.7
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,915,876.0	2,439,699.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(274,992.8)	1,329,609.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,123,229.0	0.0	18,123,229.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	17,034.8	0.0	17,034.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18,140,263.8	0.0	18,140,263.8
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	382,262.0	0.0	382,262.0
9	Тайлант үеийн үр дүн	(274,992.80)	0.0	(274,992.80)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,247,533.0	0.0	18,247,533.0
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	18,247,533.0	0.0	18,247,533.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	402,017.6	0.0	402,017.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18,649,550.5	0.0	18,649,550.5
19	Тайлант үеийн үр дүн	1,329,609.1	0.0	1,329,609.1
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	19,979,159.6	0.0	19,979,159.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,281,565.2	5,851,324.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,853,562.2	2,614,032.4
110	Орлогын албан татвар	1,542,201.9	2,074,812.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,552,114.3	2,155,566.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(9,912.50)	(80,754.30)
113	Хөрөнгийн албан татвар	73,111.7	96,122.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,238,248.7	443,098.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,893.5	10,940.7
1181	Газрын төлбөр	1,236,327.2	218,047.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	28.0	214,109.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,522,809.4	967,794.9
120	Нийтлэг татварын бус орлого	795,438.9	967,794.9
122	Тусламжийн орлого	727,370.5	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,905,193.6	2,269,497.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,530,724.2	3,834,810.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,530,724.2	3,834,810.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,239,923.5	3,555,227.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	628,935.6	1,002,096.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,495.0	159,794.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,184.2	787,127.7
2104	Хангамж, бараа материалын зардал	460,750.9	542,787.2
2105	Нормативт зардал	600.0	401.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,542.1	39,912.3
2107	Томилолт, зочны зардал	18,255.3	25,180.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	458,840.8	71,487.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	418,319.5	926,440.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,290,800.8	279,582.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,750,841.0	2,016,514.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,636,247.0	2,880,564.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,636,247.0	2,880,564.1
2200	Дотоод эх үүсвэрээр	2,636,247.0	2,880,564.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,636,247.00)	(2,880,564.10)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,114,594.0	-864,050.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	223,239.5	1,337,833.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,337,833.6	473,783.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,411,612.60	5,436,153.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,845,072.20	2,555,589.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,781,480.70	2,493,669.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	861,327.80	764,456.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,228.90	94,443.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	699,540.30	680,219.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,236.60	53,327.53
2105	Нормативт зардал	401.40	401.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,048.70	39,912.32
2107	Томилолт, зочны зардал	23,931.80	23,100.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,305.40	23,441.19
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	959,459.80	814,367.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,591.50	61,920.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,591.50	61,920.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,506,540.40	2,880,564.08
2200	Дотоод эх үүсвэрээр	3,506,540.40	2,880,564.08
223001	Бусад хөрөнгө	3,506,540.40	2,880,564.08
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	60,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,411,612.60	5,440,471.72
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,755,777.30	5,365,348.02
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,439,835.30	75,123.70
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	216,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	95,042.74
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	99,360.84
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5
610001	Төсвийн байгууллага	5	5
610002	Төсвөөс гадуур байгууллага	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	33	33
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17
620003	Үйлчлэх ажилтан	8	8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	121,525.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	121,525.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	121,525.46
2104	Хангамж, бараа материалын зардал	6,947.98
210402	Тээвэр, шатахуун	6,947.98
2107	Томилолт, зочны зардал	2,080.00
210702	Дотоод албан томилолт	2,080.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	425.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	425.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,072.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,072.23
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	121,525.46
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,525.46
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,354.18
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,171.28
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 249.7 сая төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс 249.7 сая төгрөгийн 4 зөрчилд 4 зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой

Илрүүлэлт: Тайлант оны сумын төсвийн орлогын төлөвлөгөө нийт 657.6 сая төгрөгөөр буюу 9.9 хувиар дутуу гүйцэтгэлтэй. Үүнд: үл хөдлөх хөрөнгийн албан татварын төлөвлөгөө 14.5 сая төгрөг буюу 57.9 хувиар, газрын төлбөр 118.9 сая төгрөг буюу 35.3 хувиар, төсөвт байгууллагын өөрийн орлого 23.2 сая төгрөг буюу 100 хувиар, мөн ОНХС 507.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлэх.

2. ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд 42 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ худалдан авах ажиллагаанд иргэн, аж ахуй нэгж оролцоогүй гэсэн шалтгааны улмаас хэрэгжээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн ажлын хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.

3. Сумын хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Тус сум нь 2024 оныг "Бүтээн байгуулалт, тохижилтын жил" зорилтот жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд нийт 5 бүлгийн 69 арга хэмжээ хэрэгжүүлэн ажилласан. Сумын ИТХ-ын 2024 оны 03/07 дугаар тогтоолоор 71.8 хувиар үнэлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Сумын хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг бүрэн гүйцэтгэлтэй хангаж ажиллах.

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих 166 мэдээллээс 8 мэдээллийн хугацааг хоцроосон байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулахтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудаст оруулах мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант оны сумын төсвийн орлогын төлөвлөгөө нийт 657.6 сая төгрөгөөр буюу 9.9 хувиар дутуу гүйцэтгэлтэй. Үүнд: үл хөдлөх хөрөнгийн албан татварын төлөвлөгөө 14.5 сая төгрөг буюу 57.9 хувиар, газрын төлбөр 118.9 сая төгрөг буюу 35.3 хувиар, төсөвт байгууллагын өөрийн орлого 23.2 сая төгрөг буюу 100 хувиар, мөн ОНХС 507.9 сая төгрөгөөр тус тус тасарсан.	1	149.7					1	149.7				
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд 42 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 8 төсөл, арга хэмжээ худалдан авах ажиллагаанд иргэн, аж ахуй нэгж оролцоогүй гэсэн шалтгааны улмаас огт хэрэгжээгүй.	1	100.0					1	100.0				
Тус сум нь 2024 оныг "Бүтээн байгуулалт, тохижилтын жил" зорилтот жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд нийт 5 бүлгийн 69 арга хэмжээ хэрэгжүүлэн ажилласан. Сумын ИТХ-ын 2024 оны 03/07 дугаар тогтоолоор 71.8 хувиар үнэлсэн.	1	-					1	-				
Дүн	3	249.7					3	249.7				

Халхгол сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих 166 мэдээллээс 8 мэдээллийн хугацааг хоцроосон.	1	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	1	-	-	-	-	-	1	-